



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.20 № 3/265
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Тээврийн прокурорын газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Тээврийн прокурорын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЭНХЗАЯА

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0220SAG36Docx

070181



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дара
хаягаар харилцана уу:

САГ-ын дарга, Тэргүүлэх аудитор

С. Энхзаяа

Утас: 261663

Цахим хаяг: enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер: **Н. Золзаяа**

Утас: 260512

Цахим хаяг: Zolzayan@audit.gov.mn

Аудитор: **Б.Сэржмядаг**

Утас: 260512

Цахим хаяг: serjmyadagb@audit.gov.mn

ТАБ-ын хаяг: 3Г-ын IY байр

Бага тойруу 6 Улаанбаатар -46

Цахим хуудас:

“Мишээл-Од Аудит” ХХК-ийн

Аудитын багийн ахлагч **Т.Одончимэг**

Утас: 99069029, 96659029

Ахлах аудитор: **Б.Цогзолмаа**

Ахлах аудитор: **О.Цэндхүү**

Аудиторын туслах: **Э.Энхцэцэг**

Утас: 99087892, 99065204

Хаяг: БГД 2 хороо Time center 601, 603

Вэб хуудас: www.misheelodaudit.mn

Имэйл хаяг: misheelod@yahoo.com

Аудитынтайлан

Хавсралт 1: Аудитын гэрчилгээ

Хавсралт 2: Аудитын тайлан

Хавсралт3: Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

Судалгаа:

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Материаллаг байдал
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны талаарх мэдээлэл:
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

НЭГ. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дугаар зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Тээврийн прокурорын газрын төсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд /САГ-2017/49/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Тээврийн прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Тээврийн прокурорын газар нь санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төсвийн захирагчийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 25-наас 2017 оны 02 дугаар сарын 10-ныг хүртэл хийхээр төлөвлөн багийн гишүүн “Мишээл-Од Аудит” ХХК-ийн захирал, аудитын багийн ахлагч Т.Одончимэг удирдан зохион байгуулж аудитор, туслах аудитор 3 ажилтан хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. /ТАБ-СТА-А-9/

Тээврийн прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 01 сарын 25-нд “Мишээл-Од Аудит” ХХК-д ирүүлсэн байна. Завсрын үеийн аудитыг 2016 оны 10 сарын 10-наас 11 сарын 05-ны хооронд, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 сарын 20-ноос 2017 оны 02 сарын 04-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 15-нд Тээврийн прокурорын газрын удирдлагад гардуулна.

Хоёр. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Тээврийн прокурорын газар нь Прокурорын байгууллагын тухай хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Эрүүгийн хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын Ерөнхий хууль, Авто тээврийн тухай хууль, Эрүүгийн хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль зэрэг хуулиудын болон холбогдох хууль, тогтоол, шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Гурав. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Тээврийн прокурорын газар нь МУ-ын үндсэн хуулийн 56 дугаар зүйл, Прокурорын байгууллагын тухай хуулийг удирдлага болгон УБТЗ дахь Цагдаагийн хэлтэс, ЗЦГазар, ИАТээврийн Цагдаагийн хэлтэс, Буянт-Ухаа дахь гаалийн газар, Буянт -Ухаа дахь хилийн мэргэжлийн хяналтын алба, Буянт-Ухаа дахь хилийн шалган нэвтрүүлэх боомт, Гадаадын иргэн харьяатын асуудал эрхлэх алба, УБТЗ-ын хяналтын албадын байцаагчийг хамруулан хяналтын үйл ажиллагааг явуулж нийслэл, дүүргүүдийн шүүхийн эрүүгийн шүүн таслах ажиллагаанд төрийг төлөөлөн оролцон үйл ажиллагаагаа явуулж байна.

Прокурорын байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэрт эрүүгийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг нэг мөр хангуулах үндсэн чиг үүрэг бүхий, үйл ажиллагаагаа төрийн нэрийн өмнөөс явуулдаг, бие даасан, хараат бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэхэд оролцох зорилготой.

2016 онд ажлаа сар улирлаар төлөвлөн үйл ажиллагааныхаа чиглэлээр тодорхой зорилтууд дэвшүүлэн, батлагдсан орон тоо бүтэцдээ зохицуулан ил тод байдлыг эрхэмлэн дээд шатны прокурорын даалгаврыг нэг бүрчлэн хэргэжүүлэхэд анхаарч хяналтын ажлаа чиглүүлэн ажиллаж байна.

Дээрх үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу ажиллаж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга нь төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Тээврийн прокурорын газрын 2016 оны төсвийг Улсын ерөнхий прокурорын газрын нэгдсэн төсвөөс олгож байна.

Тээврийн прокурорын газрын төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж, нэгдүгээр гарын үсгийг Балдорж овогтой Цоодол, хоёрдугаар гарын үсгийг Цэвээн овогтой Насанжаргал нар зурж төсвийн хөрөнгийг зарцуулж байна.

Тээврийн прокурорын газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно.

Дөрөв. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Тээврийн прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 15 чиглэлээр 38 уламжлалт сорил, 3 хяналтын сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаатай танилцахад Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон холбогдох хууль, журам, зааварт нийцүүлэн боловсруулсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, нягтлан бодох бүртгэлийн “Аколоус” програмтай байна. Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Бид Тээврийн прокурорын газрын ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Тав. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс

дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Тээврийн прокурорын газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хэвийн Улсын ерөнхий прокурорын газрын дотоод аудит хяналтыг хийж байна.

Зургаа. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төлөвлөлтийн үед төсвийн хуваарийн зарлагыг суурь болгон авч 412.4 сая төгрөгийн 2.0 %-иар тооцож 8.2 сая төгрөгөөр тооцож, гүйцэтгэлийн үед орлого буурсан учир материаллагын түвшинг дахин тогтоож 408.2 сая төгрөгийн 2.0 %-иар тооцож 8.1 сая төгрөгөөр тогтоон аудитын сорилуудыг гүйцэтгэхэд материаллаг хэмжээний зөрчил гараагүй болно.

Долоо. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Тайлант онд 408.3 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 408.2 сая төгрөгийн санхүүжилт авч 0.1 сая төгрөг буцаан төвлөрүүлж, биелэлт 100 хувьтай байна. Санхүүжилтийн 368.9 сая төгрөг буюу 90.3 % нь цалингийн зардал, 4.1 % нь байр ашиглалттай холбоотой зардал эзлэж байна.

Найм. Шилэн дансны мэдээлэл

2014 оны 7 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Шилэн дансны тухай хууль батлагдан мөрдөх болсонтой холбогдуулан, хуулийг хэрэгжүүлэх зорилгоор 2015 оноос хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

<http://www.shilendans.gov.mn/> цахим хуудсанд байгууллагаа бүртгүүлэн www.prokuror.mn хаяг авч, байгууллагын батлагдсан төсвийг зохих маягтын дугуу оруулж, төсвийн гүйцэтгэлийг сар бүр зохих маягтын дагуу байршуулсан байна.

<http://shilendans.gov.mn> /kod- 006001001/цахим хуудасны Төсвийн ил тод байдлын тухай гэсэн цэсэнд байгууллагын батлагдсан 2016 оны төсвийг байрлуулаад, төсвийн гүйцэтгэлийн 1-12 сарын мэдээ, харилцах, кассаас

зарцуулсан зарцуулалтууд, тендерийн бүх мэдээлэл, худалдан авалтуудыг бүрэн байршуулаад байна.

Үндэсний Аудитын газраас 2016 онд шилэн дансны гүйцэтгэлд хийсэн 1 удаагийн аудитаар зөрчил дутагдал гараагүй, зөвлөмж аваагүй байна.

Ёс. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 15 чиглэлд уламжлалт болон хяналтын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр уламжлалт 38, нарийвчилсан 3, нийт 41 горим, сорил гүйцэтгэв. Гүйцэтгэсэн сорилын үр дүнгээс харахад тус байгууллагын 2016 оны санхүүгийн тайланд материаллаг хэмжээний зөрчил илрээгүй бөгөөд үйл ажиллагааны үр дүн сайн байсан гэж бид үзсэн болно.

Арав. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар:

Тээврийн прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт ажил гүйлгээний 80.0 орчим хувь хамарсан байна.

Арван нэг. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад залруулагдах материаллаг алдаа тогтоогдоогүй болно. Аудитын явцад материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. Тээврийн прокурорын газрын үндсэн хөрөнгийн бүртгэлд бүртгэлтэй Dell Optilex-390 загварын 1 ширхэг 1,056.0 мянган төгрөгийн анхны өртөгтэй компьютерийг хулгайд алдсан мөн 3,379.5 мянган төгрөгийн анхны өртөгтэй 4 ширхэг компьютер тогны хэлбэлзлээс шалтгаалан шатсан учир ашиглах боломжгүй гэж үзсэн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон

цахимаар бичилт хийж баталгаажуулна гэсэн заалтыг биелүүлээгүй, үндсэн хөрөнгө биетээр оршин байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Завсрын аудитаар зөрчлийг арилгуулахаар ҮАГ 2016 оны 11 сарын 08-ны өдөр зөвлөмж хүргүүлсэн.

2. Шууд бус орлогоос татвар тооцохдоо НДШ хассан дүнгээс тооцож ХХОАТ-ыг дутуу ногдуулсан байна. Ажиллагсдын цалинг цаг бүртгэлийн системээс гарсан цагийн бүртгэлийн хуудсыг үндэслэхгүйгээр бодож, 5 ажилтны цалинг 703.0 мянган төгрөгийн цалин илүү, 2 ажилтны цалинг 1408.9 мянган төгрөгөөр дутуу олгосон байна. Мөн нийгмийн даатгалын тайланд 1 ажилтны цалинг 318.6 мянган төгрөгөөр дутуу, 1 ажилтны цалинг 158.1 мянган төгрөгөөр илүү тусгасан байна. Энэ нь “ХХОАТ-ын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1-д зааснаар: Энэ хуулийн 22.1.4-т /Шууд бус орлогод тухайн орлогын дүнгээр татвар ногдуулна/ зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: 2016 оны эхний 9 сарын байдлаарх нягтлан бодох бүртгэлд гарсан дээрх зөрчлийг арилгуулахаар ҮАГ 2016 оны 11 сарын 08-ны өдөр зөвлөмж хүргүүлсэн. Завсрын аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 01 сарын 25-ны өдрийн 5/98 албан тоотоор бидэнд ирүүлсэн. Зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 90 хувьтайгаар биелсэн байна. Шууд бус орлогоос татвар тооцохдоо НДШ хассан дүнгээс тооцож ХХОАТ-аас 74.6 мянган төгрөгийг дутуу ногдуулсан байсныг залруулаагүй байна. Үүнийг 2017 оноос ХХОАТ-ын хуулийн дагуу татвар тооцохоор болсон.

Арван хоёр. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Материаллаг бус залруулагдаагүй алдаа байхгүй болно.

Арван гурав. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Тээврийн прокурорын газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг баталгаажуулахаар аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний бүх ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгасан учир дараагийн аудитаар авч үзэх ноцтой асуудлууд байхгүй гэж бид үзсэн болно.

Арван дөрөв. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Санхүүгийн тайлангийн завсрын аудитын явцад 7.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлсэн. Үүнээс 7.0 сая төгрөгийн зөрчлийг арилгаж 0.1 сая төгрөгийн материаллаг бус залруулагдаагүй алдаа байна.

Арван тав. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Тээврийн прокурорын газрын 2015 оны санхүүгийн тайланд ҮАГ-аас итгэл үзүүлсэн учир аудит хийгдээгүй байна. 2016 оны санхүүгийн тайлангийн завсрын аудитыг 2016 оны 10 сарын 10-наас 11 сарын 05-ны хооронд хийж 3 зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 01 сарын 25-ны 5/98 тоотойр ирүүлснийг тайланд хавсаргасан болно.

Арван зургаа. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Зөрчилгүй санал дүгнэлт

Тээврийн прокурорын газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг хавсаргав.

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН АУДИТ ХИИГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Аудитаар баталгаажсан үлдэгдэл	
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	3,800.00	(0.00)
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банкинд байгаа бэлэн мөнгө /төгрөгөөр/	(0.00)	(0.00)
АВЛАГА	268,950.00	480,144.00
Байгууллагаас авах авлага	170,056.00	25,056.00
Хувь хүмүүсээс авах авлага	98,894.00	455,088.00
БАРАА МАТЕРИАЛ	11,831,350.00	6,729,246.00
Бичиг хэргийн материал	575,770.00	370,850.00
Аж ахуйн материал	10,961,880.00	6,062,380.00
Түлш, шатах тослох материал	293,700.00	296,016.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,104,100.00	7,209,390.00
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	57,591,056.59	72,338,932.97
Биет хөрөнгө	57,566,994.09	72,338,932.97
Авто тээврийн хэрэгсэл	46,900,000.00	69,900,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(31,918,055.61)	(41,012,500.05)
Машин, тоног төхөөрөмж	49,102,613.75	46,431,613.75
Хуримтлагдсан элэгдэл	(30,664,114.12)	(35,694,457.03)
Тавилга, аж ахуйн эд хогшил	36,307,760.00	47,005,507.45
Хуримтлагдсан элэгдэл	(12,364,469.93)	(14,494,491.15)
Номын фонд	203,260.00	203,260.00
Биет бус хөрөнгө	24,062.50	-
Програм хангамж	165,000.00	-
Хасагдуулга	(140,937.50)	-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	57,591,056.59	72,338,932.97
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	69,695,156.59	79,548,322.97
Богино хугацаат өр төлбөр	827,328.08	1,412,153.07
Өглөг	827,328.08	1,412,153.07
НДШ-ийн өглөг	788,938.08	830,128.74
Татварын өглөг /ХАОАТ/	-	175,666.33
Байгууллагад төлөх өглөг	38,390.00	406,358.00
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	827,328.08	1,412,153.07
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	827,328.08	1,412,153.07
Засгийн газрын оруулсан капитал	110,905,897.88	110,905,897.88
Өмнөх үеийн үр дүн	(42,038,069.37)	(42,038,069.37)
Тайлант үеийн үр дүн	-	9,268,341.39
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	68,867,828.51	78,136,169.90
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	69,695,156.59	79,548,322.97

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН АУДИТ ХИИГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Улсын төсвөөс	496,184,600.00	431,337,900.00
Урсгал ?йл ажиллагааны санхүүжилт	471,184,600.00	408,337,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	25,000,000.00	23,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,000,000.00	23,000,000.00
Бараа, үйлчилгээний орлого	2,160,600.00	14,947,403.45
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	2,160,600.00	14,947,403.45
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,050,600.00	-
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	1,110,000.00	14,947,403.45
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	498,345,200.00	446,285,303.45
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	506,568,653.32	436,423,616.20
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	434,232,200.58	368,813,128.13
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	389,433,976.25	331,618,312.79
Цалин	377,228,976.25	326,880,712.79
Унаа хоолны хөнгөлөлт	12,205,000.00	4,737,600.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	44,798,224.33	37,194,815.34
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	44,798,224.33	37,194,815.34
Тэтгэврийн даатгалын шимтгэл	44,798,224.33	37,194,815.34
Тогтмол зардал	16,675,799.00	17,100,306.00
Гэрэл цахилгааны зардал	2,352,624.00	2,947,176.00
Түлш, халаалтын зардал	6,277,340.00	7,563,300.00
Цэвэр, бохир усны зардал	996,900.00	646,900.00
Байрны түрээс	7,048,935.00	5,942,930.00
Хангамж, бараа материалын зардал	17,688,133.10	12,409,671.00
Бичиг хэргийн материал	8,526,326.50	4,766,270.00
Тээвэр, шатахууны зардал	4,578,300.00	4,150,700.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	3,293,538.60	2,856,036.00
Ном, хэвлэлийн зардал	176,600.00	-
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	1,113,368.00	636,665.00
Нормативт зардал	673,400.00	204,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	673,400.00	204,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	2,778,172.00	12,713,000.00
Урсгал засвар	2,778,172.00	12,713,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хур	55,000.00	11,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээн	-	11,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	55,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	34,465,948.64	25,172,511.07
Бусад зардал	13,411,000.00	2,400,000.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	500,200.00	-
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	20,554,748.64	22,772,511.07
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,248,318.90	593,345.86
Засгийн газрын урсгал шилжүүлэг	388,318.90	93,345.86
Төвлөрүүлэх шилжүүлэг	388,318.90	93,345.86
Бусад урсгал шилжүүлэг	2,860,000.00	500,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,860,000.00	500,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	509,816,972.22	437,016,962.06
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	(11,471,772.22)	9,268,341.39
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(11,471,772.22)	9,268,341.39

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	110,905,897.88	0.00	-30,566,297.11	0.00	80,339,600.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	110,905,897.88	0.00	-30,566,297.11	0.00	80,339,600.77
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-11,471,772.22	0.00	-11,471,772.22
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2015 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	110,905,897.88	0.00	-42,038,069.37	0.00	68,867,828.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	110,905,897.88	0.00	-42,038,069.37	0.00	68,867,828.51
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	9,268,341.39	0.00	9,268,341.39
Үндсэн хөрөнгийн нэмэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	110,905,897.88	0.00	-32,769,727.98	0.00	78,136,169.90

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Аудитаар баталгаажсан дүн	
	Өмнөх он	Тайлант он
Тусламж, санхүүжилтын орлого	496,184,600.00	431,337,900.00
Улсын төсвөөс	471,184,600.00	408,337,900.00
Урсгал	471,184,600.00	408,337,900.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	25,000,000.00	23,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	25,000,000.00	23,000,000.00
Бараа, үйлчилгээний орлого	1,050,600.00	-
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	1,050,600.00	-
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	1,050,600.00	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	497,235,200.00	431,337,900.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	493,983,081.10	407,748,354.14
Ажиллагчидтай холбогдсон зардал	433,191,500.00	368,952,465.14
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	390,363,100.00	331,294,765.14
Цалин	378,158,100.00	326,557,165.14
Унаа хоолны хөнгөлөлт	12,205,000.00	4,737,600.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	42,828,400.00	37,657,700.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	42,828,400.00	37,657,700.00
Бараа үйлчилгээний урсгал зардал	60,791,581.10	38,795,889.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	18,212,609.00	17,062,000.00
Гэрэл цахилгааны зардал	2,282,624.00	2,919,900.00
Түлш, халаалтын зардал	8,620,150.00	7,563,300.00
Цэвэр, бохир усны зардал	932,130.00	646,900.00
Байрны түрээс	6,377,705.00	5,931,900.00
Хангамж, бараа материалын зардал	15,153,420.10	11,822,889.00
Бичиг хэрэг	6,101,346.50	4,416,350.00
Тээвэр, шатахуун	2,846,000.00	4,040,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,592,505.60	2,526,374.00
Ном, хэвлэл	1,676,600.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	936,968.00	840,165.00
Эд хогшил, урсгал засварын зардал	1,758,072.00	7,500,000.00
Урсгал засвар	1,758,072.00	7,500,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	11,000.00	11,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ	-	11,000.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	11,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	25,656,480.00	2,400,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	25,156,280.00	2,400,000.00

Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	500,200.00	-
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,248,318.90	593,345.86
Засгийн газрын урсгал шилжүүлэг	388,318.90	93,345.86
Төвлөрүүлэх шилжүүлэг	388,318.90	93,345.86
Бусад урсгал шилжүүлэг	2,860,000.00	500,000.00
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	2,860,000.00	500,000.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	497,231,400.00	408,341,700.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)	3,800.00	22,996,200.00
Хөрөнгийн орлого	-	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	23,000,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	23,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	23,000,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(23,000,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Засгийн газрын бондын үндсэн төлбөр	-	-
Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	3,800.00	(3,800.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(0.00)	3,800.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,800.00	(0.00)

**ТЭЭВРИЙН ПРОКУРОРЫН ГАЗРЫН АУДИТ ХИЙГДСЭН
2016 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

2016 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон тайлант жил

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	Аудитаар баталгаажсан үлдэгдэл			
	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	408,337,900.00	408,248,354.14	89,545.86	100.00
II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	408,337,900.00	408,248,354.14	89,545.86	100.00
IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	408,337,900.00	408,248,354.14	89,545.86	100.00
Бараа, үйлчилгээний зардал	407,837,900.00	407,748,354.14	89,545.86	100.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	331,381,200.00	331,294,765.14	86,434.86	100.00
Үндсэн цалин	326,643,600.00	326,557,165.14	86,434.86	100.00
Унаа, болон бусад нөхөн олговор	4,737,600.00	4,737,600.00	-	100.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,657,700.00	37,657,700.00	-	100.00
Тэтгэврийн даатгал	20,918,200.00	20,918,200.00	-	100.00
Тэтгэмжийн даатгал	2,451,300.00	2,451,300.00	-	100.00
ҮОМШӨ ний даатгал	3,353,800.00	3,353,800.00	-	100.00
Ажилгүйдлийн даатгал	898,700.00	898,700.00	-	100.00
Байгууллага төлөх ЭМД ийн хураамж	10,035,700.00	10,035,700.00	-	100.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	17,062,000.00	17,062,000.00	-	100.00
Гэрэл цахилгаан	2,919,900.00	2,919,900.00	-	100.00
Түлш, халаалт	7,563,300.00	7,563,300.00	-	100.00
Цэвэр, бохир ус	646,900.00	646,900.00	-	100.00
Байрны түрээс	5,931,900.00	5,931,900.00	-	100.00
Хангамж, бараа материалын зардал	11,826,000.00	11,822,889.00	3,111.00	100.00
Бичиг хэрэг	4,327,400.00	4,416,350.00	(88,950.00)	102.10
Тээвэр (шатахуун)	4,040,000.00	4,040,000.00	-	100.00
Шуудан холбоо	2,618,400.00	2,526,374.00	92,026.00	96.50
Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	840,200.00	840,165.00	35.00	100.00
Эд хогшил худалдан авах	7,500,000.00	7,500,000.00	-	100.00
Урсгал засвар	7,500,000.00	7,500,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	11,000.00	11,000.00	-	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	11,000.00	11,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
Бараа үйлчилгээний бусад зардал	2,400,000.00	2,400,000.00	-	100.00
ТАТААС	500,000.00	500,000.00	-	100.00
Бусад урсгал шилжүүлэг	500,000.00	500,000.00	-	100.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	500,000.00	500,000.00	-	100.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	408,337,900.00	408,248,354.14	89,545.86	100.00
Төсвөөс санхүүжих	408,337,900.00	408,248,354.14	89,545.86	100.00
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	3,800.00	(3,800.00)	-
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	(0.00)	0.00	-
БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
АЖИЛЛАГСАД БҮГД	28.00	28.00	-	100.00
Удирдах ажилтан	4.00	4.00	-	100.00
Гүйцэтгэх ажилтан	11.00	11.00	-	100.00
Үйлчлэх ажилтан	13.00	13.00	-	100.00
СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-